

ОЮУТНЫ ЭЗЭМШИХ ЁСТОЙ НИЙГМИЙН ЧАДВАНУУД

Б. Дорж
ХИС-ийн ГХС Сургууль
Battulgadorj2@gmail.com

Үндсэн ойлголт

Хүн эхээс мэндлэхэд биологийн амьтан байдаг. Харин оюун ухаан, сэтгэл санааны хувьд байгалийн амьтан байдаг. Гэр бүл, сургууль, хамт олон гэх мэт нийгмийн микро, макро орчинд эцэг эхийн хайр халамж, ахмад хүмүүсийн үлгэр дуурайлал, багш сурган хүмүүжүүлэгчдийн тусламжтайгаар суралцаж, хүмүүстэй харилцан үйл ажиллагаанд оролцох, гурван түвшинт боловсролын агуулгыг эзэмших замаар нийгэмшин нийгмийн гишүүн, бие хүн болдог.

Хүснэгт 1

XXI зууны боловсролын агуулгын
гурван түвшинт бүтэц [2].

Гуравдугаар түвшин	Нийгмийн чадвар
Хоёрдугаар түвшин	Мэргэжлийн чадвар
Нэгдүгээр түвшин	Суурь чадвар

Их, дээд сургуулийн оюутан залуусын хувьд бол нас, сэтгэцийн хувьд тодорхой хэмжээгээр ахиж суурь чадваруудыг эзэмшсэн, мэргэжлийн болоод нийгмийн чадварын анхан шатны суурь түвшинг эзэмшиж байгаа үе байдаг.

Нийгмийн чадвар гэдэг бол нийгэм хүмүүсийн дунд ажиллаж, сурч, амьдарч байгаа хүн бүхэний амьдралын алхам бүрд тулгарч байдаг хүмүүстэй хүний ёсоор харилцах зан төлөв, ёс суртахууны эерэг хэм хэмжээ, зөв дадал зуршил, эерэг чанаруудын цогц юм. Чадвар гэдэг утгаар нь авч үзвэл бодгаль хүнд мэдүүлж, эзэмшүүлж, төлөвшүүлж, хөгжүүлж болох жолоодогдох шинжтэй, сурган хүмүүжүүлэх үйл явцын нэг объект мөн.

Манай орны боловсролын ирээдүйн шинэчлэлийн нэг чухал хэсэг болох суралцагсдад эзэмшүүлэх нийгмийн чадвар гэдэгт "боловсролтой иргэн хүний ерөнхий төлөвшил, үзэл баримтлал, тасралтгүй сурах хэрэгцээ, системтэй категороор сэтгэх бизнесийн сэтгэлгээ, өөрийгөө удирдах, бусадтай хамтран багаар ажиллаж амьдрах бусдын үзэл бодлыг хүндэтгэх, зөвшилцлөөр шийдвэр гаргах, хатуу бэрхийг даван туулах, ажил хэрэгч тууштай, үнэнч чанар эзэмших, өөртөө болон нийгэм хамт олны өмнө хариуцлага хүлээж сурах зэрэг иргэнлэг чанарууд багтана.

Судлаачдын үзэж байгаагаар иргэний нийгмийн чадварт дараах багц чанар багтана [2]. Үүнд :

- Хүнлэг ёс, нинжин сэтгэлт
 - Аливаа юуманд өөдрөгөөр хандах
 - Бусдын үзэл бодлыг хүндэтгэх

- Бусдын зовлонг ойлгох хуваалцах
- Шударга ёс
 - Бусдад хариу нэхэлгүй тусалдаг байх
 - Үнэн сэтгэлээсээ нөхөрлөж чаддаг
- Энэрэн нигүүлсэх чанар
 - Бие биедээ урам хайрлах, элгэмсүү хандах
 - Бусдад туслахад бэлэн байх
 - Бусдыг тэвчээр гарган анхаарлаа төвлөрүүлэн сонсох
 - Бусдыг ойлгох, бусадтай ойлголцох чадвар
 - Амьтан, ургамлыг хайрлах ухаан
 - бусад хүмүүстэй харилцах чадвар
 - Хүмүүстэй нөхөрсгөөр мэндэлдэг
 - Хэл ярианы соёлтой харилцаатай байх
 - Бусад хүмүүстэй харилцаж байхдаа зөв эвсэг харилцааг бий болгох
 - Хүнд үйлчилж халамж, анхаарал тавьж чаддаг, үйлчилгээ үзүүлж чаддаг байх
 - Бусдаас шүүмжлэл сонсож, санааг нь тусгаж өөрөө биелүүлдэг
 - Олны дунд тааруулж, тохируулж хувцасладаг байх
- Багаар хамтран ажиллах
 - Ний нуугүй зөвшилцөж чаддаг байх
 - Хамтын оюун ухаанаар аливаа асуудлыг шийдвэрлэх чадвар
 - Бусадтай эвтэй найртай хамтран амьдрах чадвар
 - Нэгдмэл санаатай, эв найртай хамтран ажиллах
 - Бусдын хөдөлмөрийн үр дүнг хүндэтгэх чадвар
- Өөрийн үйл ажиллагааг төлөвлөх чадвар
 - Өөрийгөө илэрхийлэх чадвар
 - Өөрийн хэрэгцээ сонирхолыг өрөөлийнхтэй харицуулах чадвар
 - Өөрийн болон бусдын өмнө хариуцлага хүлээх
 - Зорьсон зүйл амалсандаа хүрдэг чанар
 - Өөртөө шүүмжлэлтэй ханддаг
 - Олны дунд өөрийгөө хянан жолоодож чаддаг.
- Тасралтгүй сурах идэвх
 - Зорьсноо биелүүлэхийн төлөө тэмцдэг тууштай чанар
 - Бүтээлч хандлага
 - Нийгмийн үйл хэрэгт идэвхитэй, санаачлагатай оролцдог байх
 - Өөрчлөлт шинэчлэлд зохицох чадвар
 - Олон хэлээр харилцаж хэнтэй ч үг хэлээ

олдог байх зэрэг чадварууд юм.

Эдгээр чадварууд бол үндсэндээ яаж хүн болох вэ ?, хүн өөрийгөө нийгмийн дунд хэрхэн авч явах вэ ? гэдэгтэй холбоотой нэг үгээр хэлбэл хүмүүнлэгийн хичээлээр судлаж эзэмших чадвар дадал юм. Глобаль өөрчлөлтийн орчинд амьдрахад шаардагдах эдгээр чадварууд нь өнөөгийн боловсролын нийтлэг агуулга, зорилготой ч нийцэж байгаа юм. Энэхүү иргэнлэг чанарууд бол даяарчлалын нийгэмд дасан зохицох чадвар юм.

Түлхүүр үг: оюутан, оюутан нас, мэдлэг эзэмшилт, мэдлэг, чадвар, дадал, нийгэм, нийгмийн чадвар

1. Судалгааны хэсэг

Судалгааг асуулгын аргаар санамсаргүй түүврээр 2010 оны хоёр, гуравдугаар сард авсан бөгөөд судалгаанд Ховд их сургууль, Ховд эрдэм дээд сургуулийн 3,4-р ангийн нийт 98 оюутан, оролцсон болно. Оюутнуудыг харъяаллын хувьд авч үзвэл ХИС-ийн 81 оюутан, ХААИС-ын 8, Ховд эрдэм дээд сургуулийн 9 оюутан оролцсон болно. Хүйсийн хувьд 72.4% нь эмэгтэй 27.6% нь эрэгтэй байна. мөн эдгээр сургуулийг төгсөгч 93 хүнээс судалгаа авсан юм. Ингээд судалгааны үр дүнтэй танилцъяа.

- Юуны өмнө оюутнуудын мэдлэг, чадвар, дадлыг зөв үнэлэх асуудал нь оюутнуудын нийгмийн чадварыг хөгжүүлэх, аливаа зүйлд үнэн зөв, шударга хандахад нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм. Судалгаанд хамрагдагчдын 9.3% нь сурлагын дүнгээ “миний мэдлэгээс доогуурдуу, 5.2% нь “дээгүүрдүү” 25% нь “ойролцоодуу” гэсэн атал дийлэнх олонх буюу 60.5% нь “янз бүр л байдаг” гэжээ. Үүнээс үзвэл сурлагын дүн тэдний бүрэн хэмжүүр биш ч гэсэн үе үеийн оюутнууд, эрдэмтэн мэргэд түүгээр хэмжигдэн ирсэн түүхэн уламжлалыг үгүйсгэх аргагүй юм. Оюутнуудын зарим нь мэдлэгийн төлөө, орчин үеийн техник технологийг эзэмшихийн төлөө гэхээсээ дүнгийн төлөө, дипломын төлөө суралцаж байгаа нь нууц биш юм.

Та дараах зүйлсийг хэр зэрэг эзэмшсэн бэ? гэсэн асуултанд дараах байдлаар хариулжээ.

Хүснэгт 2.

	Бараг эзэмшээгүй	Амиа аргална	Чөлөөтэй эзэмшсэн	Хариулаагүй	Бүгд
Монгол бичиг	10.0	55.4	30.4	3.8	100.0
Компьютер	25.4	65.2	7.3	2.1	100.0
Англи хэл	40.0	50.9	6.2	2.9	100.0
Орос хэл	17.5	64.2	17.5	0.8	100.0
Төрөлх хэл	2.9	21.9	74.6	0.6	100.0

- Та ирээдүйн ажил мэргэжлээ хэр эзэмшсэн бэ? гэсэн асуултанд 17.7% нь бараг эзэмшээгүй,

66.0% нь зарим хэсгүүдийг нь, 15.4% нь нарийн ширийн зүйлсийг хүртэл мэднэ гэжээ. Энэ хариулт нь манай оюутнуудын хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх, хөрвөх чадвараар сул байгаагийн гол шалтгаан нь юм.

- Та сургууль мэргэжлээ хэрхэн сонгосон бэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 21.9% нь “түрүүнд нь сургуулиа”, 38.7% нь “түрүүнд нь мэргэжилээ”, 18.2% нь “хоёуланг зэрэг бодолцсон”, таван хүн тутамын нэг нь тодорхой хариулт өгөөгүй байна.

- Та бололцооныхоо хэрээр суралцаж чаддаг уу? гэсэн асуултанд 51.4% нь бололцооныхоо хэрээр, 32.4% нь бололцооноосоо доогуур, дөнгөж 1.9% нь бололцооноосоо дээгүүр суралцаж, 14.3% нь хэлж мэдэхгүй байна гэж хариулсан нь өнөөгийн оюутнуудын сурах сонирголоор тааруухан байгааг илтгэж байна.

- Оюутны хамт олонсог байдлыг судалж үзвэл:

Хүснэгт 3.

	Ангараа	Хэсэг бүлгээрээ	Амь амиараа	Хариулаагүй	Бүгд
Хичээл давтахад	5.8	62.4	29.8	2.0	100.0
Шалгалт өгөхөд	49.8	34.8	15.1	0.3	100.0
Чөлөөт цагаа өнгөрөөхөд	12.0	58.8	27.9	1.	100.0
Амралтаа өнгөрүүлэхэд	10.8	42.6	43.8	2.8	100.0
Улс төрд оролцоход	21.9	33.9	41.6	2.6	100.0

Өнөөдрийн оюутнууд шинэ зуунд амьдрагчид төдийгүй түүнийг урлан бүтээгчид мөн. Иймд тэдний амьдралын төлөвлөгөөг зүй ёсоор сонирхох учиртай юм.

Хүснэгт 4

Оюутнуудын амьдралын төлөвлөгөө

Та сургуулиа төгсөөд яах бодолтой вэ ?	хувь	Та ямар байгууллагад ажиллах хүсэлтэй вэ ?	Хувь
Магистрантурт сурна	23.5	Төсвийн байгууллага	29.0
Өөр сургуульд элсэнэ	25.4	Улсын үйлдвэрийн газар	6.6
Мэргэжлээрээ ажиллана	23.2	Хувийн кампани	17.7
Ямар ч болов ажиллана	11.1	Хамтарсан кампани	27.4
Удирдах ажил хийнэ	2.1	Нөхөрлөл	0.6
Эрдмийн ажил хийнэ	1.9	Хоршоо	0.3
Бизнес эрхэлнэ	1.9	Гадны байгууллага	2.1
Гадаадад явна	10.5	Гадаадад ажиллана	14.3
Хариулаагүй	0.3	Хариулаагүй	19.0
Бүгд	100.0	Бүгд	100.0

- та ирээдүйгээ ямар хугацаагаар төсөөлж чадаж байна вэ? гэсэн асуултанд 52.5% нь хэд хэдэн жилээр, 29.8 нь жилээр, 11.0 нь сар улирлаар, үлдэх нь бүр ч богино хугацаагаар гэж хариулжээ.

- Судалгаанаас үзвэл манай оюутнуудын 46.2% нь ар гэрийнхээ, 43.6% нь төрийн сангийн, 4.4% нь өөрийн олсон зардлаар, 5.8% нь ивээл тэтгэлгээр суралцаж байна. Энэ бол нэг дэх гачаал. Хоёр дахь нь халаасны мөнгөний гачаал. Оюутнуудыг нэн хэрэгцээтэй 4 зүйлийг нэрлүүлхэд давхардсан тоогоор 92.7% нь мөнгө, 81.4% нь сурах бичиг, 69.5% нь компьютер, 56.2% нь орон сууц 51.1% нь гадаад хэл гэжээ.

- оюутнуудын сэтгэл ханамж бол нарийвчлан судлуулштай асуудал мөн.

Хүснэлт 5

Оюутнуудын сэтгэл ханамжийн байдал

	хангалуун	Дунд зэрэг	Дурамжхан	Хариу. булсаагүй	Бүгд
Ажилдаа	49.1	44.2	6.0	0.6	100.0
Мэргэжилдээ	56.4	36.0	7.0	0.6	100.0
Суугаа хотдоо	50.9	37.1	10.5	1.5	100.0
Хамт олондоо	62.7	30.5	5.3	1.5	100.0
Багш нартаа	37.1	52.0	10.0	0.8	100.0
сургуульдаа	49.4	40.2	7.9	2.4	100.0
Сурах орчиндоо	23.3	53.5	22.0	1.2	100.0
Цаг үедээ	28.7	44.2	25.0	2.1	100.0
Цаг үедээ	28.7	44.2	25.0	2.1	100.0

Өнөөгийн зах зээлийн нөхцөлд ажиллаж, амьдрах мэргэжилтэй боловсон хүчинд нийгмээс шинэ шаардлага тавих боллоо. тэрхүү эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгааг дээрх сургуулиудын төгсөгчдөөс авсан түүвэр судалгааны дүнгээс үзэж болно.

Энэ судалгааны дүнгээс хархад төгсөгчдийн 80% нь гадаад хэл, 69.0% нь хүнтэй ажиллах арга барил, 53.8 нь менежментийн мэдлэг, 19.2% нь зохион багуулах ажлын эв дүй. 22.1 нь бусдад бодол саанаагаа ойлгуулж чадаагүй гэж хариулжээ. Энэ бол их, дээд сургуулийн сургалтын агуулгад нэмэлт, өөрчлөлт хийх талаар өөгч байгаа анхааруулга, нийгмийн захиалга гэж ойлговол зохино.

Монголын пүүс кампанид ажиллагсдад тавьж байгаа нийгмийн чадваруудын хэрэгцээ, шаардлага [2].

Хүснэлт 6

д/д	Нийгмийн чадварууд	Эзлэх хувь
1	Мэргэшсэн байх	100
2	Англи хэлээр ярьж бичдэг	93
3	Орос хэлээр ярьж бичдэг	21.4
4	Компьютерийн хэрэглээтэй	93
5	Удирдаж зохион багуулах ур дүйтэй	35.7
6	Үнэнч шударга итгэлтэй	35.7
7	Харилцааны өндөр соёлтой	100
8	Хариуцлага хүлээх чадвартай	14.3
9	Хувийн зохион байгуулалт сайтай	21.4
10	Багаар ажиллах чадвартай	82.6
11	Бие даан ажиллах чадвартай	14.3
12	Төсөл бичиж боловсруулах	14.3
13	Бүтээлч, шийнийг эрэлхийлдэг	7.1
14	Тууштай,	7.1
15	Судалгаа хийж шинжлэн дүгнэх	14.3
16	Тогтвор суурьшилтай ажиллах	21.4
17	Шинэ сэтгэлгээ, идэвхи санаачлагатай	21.4
18	Өөрийгөө хөгжүүлэх эрмэлзэлтэй	21.4
19	Нөхөрсөг хамтач	7.1

Дүгнэлт

Дээрхээс дүгнэж үзвэл өнөөгийн оюутнуудад нийгмийн зүгээс дараах шаардлагууд тавигдаж байна. Үүнд,

- Өнөөгийн оюутнуудад мэргэжлийн мэдлэг чадваруудаас гадна ёсзүй, харилцааны соёл, төлөвшилийг шаардах болсон.
- Судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд оролцсон монголын аж ахуй нэгж, пүүс компаниудын 93% нь компьютерийн хэрэглээний программ дээр чөлөөтэй ажилладаг. 93% нь англи хэлээр чөлөөтэй ярьж бичдэг 35.7% нь ажилдаа үнэнч шударга итгэлтэй, 100% харилцааны өндөр соёлтой, 82,6% нь багаар хамтран ажилладаг, 21.4% нь хувийн зохион байгуулалт сайтай байх шаардлага тавьдаг байна.
- Оюутнуудын эзэмшиж буй мэдлэг, чадварууд нь нийгмийн шаардлаганд тэр бүр тохирохгүй байна.

Ном зүй

1. Бэгз Н. (2001) Глобальчлалын үеийн Монгол улсын боловсролын хөгжлийн онол, арга зүйн үндсэн асуудлууд. УБ.,
2. Монгол улс 21-р зуун: (1997) Эдийн засаг нийгмийн шинэ бодлого. УБ.,
3. Монгол улсын дээд боловсролын шинэчлэл: (1997) "Үндэсний семинарын материал".
4. Монгол улсын статистикийн эмхтгэл 2007. УБ., 2008
5. Мягмар О. (2000) Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. УБ.,
6. Оюунгэрэл Ц., Цогзолмаа Д. (2004) Мэргэжил сонголт сурлагын чанарт нөлөөлөх нь. УБ